



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.06.10 № 182
танай -ны № -т

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

"Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт,
зарцуулалт, үр нөлөө, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн
аудитын тайланг хүргүүлж байна.

Хавсралт.....хуудастай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/07

Эрдэнэт

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/207 дугаар тушаалын тавдугаар хавсралтаар батлагдсан Аймаг, Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторов эрх үүргийн 2.4 дэх хэсэг, "Төрийн аудитын байгууллагын аудит хийх журам"-ын 18.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1."Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн" гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар, аймгийн Засаг дарга, Баян-Өндөр сумын Засаг дарга, Жаргалант сумын Засаг дарга нарт хүргүүлсүгэй.

4. Аудитын тайланд дурдагдсан зөрчлүүдийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга /С.Батжаргал/, Баян-Өндөр сумын Засаг дарга /Б.Баасансүрэн/, Жаргалант сумын Засаг дарга /Б.Зоригтбаяр/ нарт зөвлөсүгэй.

5. Аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2022 оны 4 дүгээр улиралд гарган танилцуулахыг ахлах аудитор Б.Буян-Ундрах, аудитор Ж.Наранчимэг, Д.Цогбадрах нарт даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ҮР НӨЛӨӨ, ҮР ДҮН

БНА/2022/-30-ШТА-ГА



**Хөрөнгийн зарцуулалтад зарим холбогдох хууль тогтоомжийг мөрдөж
ажиллаагүй, хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.**

Орхон аймаг
2022 он
Агуулга

Аудитыг гүйцэтгэсэн:	Товчилсон үгийн тайлбар	1
	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, аудит хийх үндэслэл.	2
Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах	Үндсэн мэдээлэл	4
Ахлах аудитор: Б.Буян-Ундрах	БҮЛЭГ 1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг хууль журамд заасны дагуу хуваарилсан хэдий ч аймгийн ОНХС-аас сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 78.7 сая төгрөгөөр дутуу хуваарилсан байна.	5
Аудитор: Д.Цогбадрах Ж.Наранчимэг	1.1 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлсэн хэдий ч сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 78.7 сая төгрөгөөр дутуу хуваарилсан байна.	5
2022 оны 06 дугаар сар	1.1.2 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг батлагдсан аргачлалын дагуу тооцон төлөвлөж, санд олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу олгосон байна.	4
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70357955, 70350757 дугаарын утас, 70359826 дугаарын факсаар харилцана уу.	1.1.3 Аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 78.7 сая төгрөгөөр дутуу хуваарилсан байна.	5
Уг тайланг УАГ-ын веб сайтаас үзнэ үү.	1.1.4 Сумын ОНХС-д хуулиар олгогдох эх үүсвэрийн боломжийг судалж, орон нутгийн хөгжлийн санд нэмж төлөвлөхөөр ажиллаж байна.	5
www.audit.mn	1.2 Иргэдийн саналаар дэмжигдээгүй, хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдаагүй ажлыг төлөвлөж, ИТХ-аар баталсан байна.	5
Хаяг: Орхон аймаг дахь төрийн аудитын газар	1.2.1 Иргэдээс санал авч эрэмбэлэгдээгүй ТАХ-үүдийг аймаг, сумдын ИТХ-аар батлуулсан байна.	5
Баян-Өндөр сум, Хүрэнбулаг баг, Нутгийн удирдлагын ордон	1.2.2 ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн зарим ТАХ-г төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулаагүй байна.	6
	1.2.3 Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр чиг үүрэгт нийцээгүй болон сумын хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр баталсан байна.	7
	БҮЛЭГ.2 ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад зарим холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүйгээс үр дүн муутай ажлууд хийгдсэн байна.	7
	2.1 ОНХС-ийн хөрөнгөөр ТАХ хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийн зарим заалтыг зөрчсөн байна.	7
	2.1.1 Сангийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг хуулийн зарим заалтуудыг зөрчин зохион байгуулсан байна.	9
	2.1.2 Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.	10

2.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-г үндэслэлтэй төлөвлөж, үр дүнг бодитой тодорхойлоогүйгээс хүндрэл бэрхшээл тулгарч, үр дүн муутай ажлууд хийгдсэн байна.	10
2.2.1 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-г үндэслэлтэй төлөвлөж, үр дүнг бодитой тодорхойлоогүйгээс хүндрэл бэрхшээл тулгарч байна.	11
2.2.2 Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээ нь ирээдүйд орон нутгийн хөгжилд хувь нэмрээ оруулахаар байна.	12
2.2.3 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон зарим хөрөнгө ашиглалтын шаардлага хангахгүй байна.	13
БҮЛЭГ.3 ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах тодорхой арга хэмжээ авч, удирдлагын мэдээллийн системд мэдээллээ бүрэн оруулах шаардлагатай байна.	13
3.1 Аймгийн Засаг даргын дэргэдэх СХАА-аас ОНХС-ийн 2020 оны үйл ажиллагаанд, 2021 оны хэрэгжүүлсэн ажлуудын захиалагчийн хяналтыг “Хот байгуулалт, барилга захиалагчийн алба” ОНӨААТҮГ-аас хэрэгжүүлсэн бол аймаг, сумдын ИТХ-аас ямар нэгэн хяналт хэрэгжүүлээгүй байна.	13
3.1.1 Аймаг, сумдын ИТХ-аас ОНХС-ийн зарцуулалт, ТАХ-ны үр дүнд хяналт хэрэгжүүлээгүй байна.	14
3.1.2 ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.	14
3.1.3 СХАА-аас 2 суманд хийсэн хяналт шалгалтын зөвлөмжийн хэрэгжилт тайлант онд бүрэн хангагдсан байна.	15
3.2 ОНХС-ийн үйл ажиллагааны явцын мэдээг холбогдох байгууллагад хүргүүлсэн хэдий ч сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнг удирдлагын мэдээллийн системд хангалтгүй мэдээлсэн байна.	16
3.2.1 ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээний тайлан мэдээг дээд шатны байгууллагад хүргүүлэхдээ хууль, журамд заасан хугацааг баримталж ажилласан хэдий ч ХБТХОХ нь цаашид даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулаагүй байна.	17
3.2.2 Жаргалант сумын ОНХС-ийн хөрөнгөөр 69.3 сая төгрөгийн өртгөөр хийгдсэн зураг, төсвүүдийг нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнаагүй байна.	18
3.2.3 Сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнг удирдлагын мэдээллийн системд хангалтгүй мэдээлсэн байна.	19
3.2.4 ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтын талаар Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цаг тухай бүрд нь мэдээлсэн байна.	19
Дүгнэлт.....	

Зөвлөмж.....

20

Холбогдох байгууллагын санал.....

21

23

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
АОНХС	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан
БИНХ	Багийн Иргэдийн нийтийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчид
МУ	Монгол улс
НББ	Нягтлан бодох бүртгэл
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ОНО	Олон нийтийн оролцоотой
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
СЗДТГ	Сумын Засаг даргын Тамгын газар
СОНХС	Сумын орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлэх сан
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТТХ	Төсвийн тухай хууль
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт
ХА	Харьцуулалтын арга
ХБТХОХ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
СТСХ	Санхүү, Төрийн сангийн хэлтэс
ХААГ	Хөдөө аж ахуйн газар
ХБББ	Хөгжлийн бодлогын баримт бичиг
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ШГ	Шууд гэрээ
ТББ	Тендерийн баримт бичиг

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны “Аудитын сэдэв батлах тухай” 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн хийж гүйцэтгэв.

Аудитын зорилт:

ОНХС-ийн 2021 оны хөрөнгийн зарцуулалтад хууль тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэлээ. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх.

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад аймгийн болон 2 сумын ОНХС-ийн хөрөнгийн 2021 оны үйл ажиллагаа, аймаг, сумдын ИТХ, ЗДТГ, СТСХ, баг, хорооны ИНХ-ыг хамрууллаа.

Аудитын арга зүй:

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмжийг боловсрууллаа.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад асуудлын шинжилгээний асуултын дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүйтэй холбоотой дараах хууль, эрх зүйн актын холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;
- Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- МУ-ын Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”
- Сангийн сайдын 2018 оны 288 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”
- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”
- Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”
- Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжүүд;
- Барилга, байгууламжийн батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, байгуулсан гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд.

Аудит хийж гүйцэтгэсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах хянан удирдаж, ахлах аудитор Б.Буян-Ундрах, аудитор Д.Цогбадрах, Ж.Наранчимэг нар төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу нэгдсэн удирдамжаар хийж гүйцэтгэв.

Аудитыг гүйцэтгэсэн хугацаа:

Аудитын талбарын ажлыг 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрөөс, тайлагналын үе шатны ажлыг 05 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн, тайланг 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн дотор үе шатны хяналтаар оруулж, Тэргүүлэх аудитораар баталгаажуулж, 2022 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлээ.

Үндсэн мэдээлэл:

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.28-т “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан гэж орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгохоор дахин хуваарилалт хийх хөрөнгийг хэлнэ” гэж заасан байна.

Засгийн газрын 2012 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 30 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ыг Засгийн газрын 2017 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 230 дугаар тогтоолоор хүчингүй болгож, “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал батлах тухай” тогтоолыг тус тус баталсан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг төлөвлөх, батлах, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, бүртгэх, тайлагнах, хяналт тавих үйл ажиллагааны журмыг Сангийн сайдын 2014 оны 03 дугаар сарын 06-ний өдрийн 43, 2018 оны 09 дүгээр 12-ний өдрийн 228 дугаар тушаалаар батлан мөрдөж байсан бөгөөд Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ыг шинэчлэн баталжээ.

Олон Улсын Хөгжлийн Ассоциаци болон Монгол Улсын Засгийн газрын хооронд 2015 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр “Тогтвортой амьжиргаа 3” төслийг хэрэгжүүлэхээр Зээл №5487-MN тоот санхүүжилтийн хэлэлцээр хийсэн бөгөөд тус төсөл нь хөдөө орон нутагт тэргүүлэх ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоо, засаглалыг сайжруулах зорилготой үйл ажиллагаа явуулж байна. Энэ хүрээнд Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 4 дүгээр хавсралтаар Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр буюу дээрх төслөөс 2021 онд Орхон аймагт 126.6 сая төгрөгийн дэмжлэг, 163.4 сая төгрөгийн урамшуулал олгохоор баталжээ.

ОНХНС-аас Орхон аймгийн ОНХС-д олгосон орлогын шилжүүлэг /сая төгрөг/

№	Аймаг	Сум, дүүргийн тоо	ОНХНС-аас олгох орлогын шилжүүлэг	Үүнээс "Тогтвортой амьжиргаа 3" төслийн	
				Дэмжлэг	Урамшуулал
21	Орхон	2	5,353.7	126.6	163.4

Орхон аймаг дахь
Төрийн аудитын
газар

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх:

Бүлэг 1

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг хууль журамд заасны дагуу хуваарилсан хэдий ч аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 78.7 сая төгрөгөөр дутуу хуваарилсан байна.

1.1 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлсэн хэдий ч сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 78.7 сая төгрөгөөр дутуу хуваарилсан байна.

1.1.2 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг батлагдсан аргачлалын дагуу тооцон төлөвлөж, санд олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу олгосон байна.

Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэхээр заасан байна.

- Импортоос бусад бараа, ажил, үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын 5 хувь
- Ашигт малтмалын тухай хуулийн 47³ дугаар зүйлд зааснаас бусад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 5 хувь
- Орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоодын төрийн бус байгууллагын болон гадаадын албан ёсны тусламж, хандив, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг
- Газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогын 30 хувь

2021 оны Төсвийн тухай хуулиар ОНХНС-аас 2021 онд Орхон аймгийн ОНХС-д 5,353.7 сая төгрөгийн орлогын шилжүүлэг хуваарилахаар баталсан байна. Орлогын шилжүүлгээс хуваарилах дүнг нэр төрлөөр авч үзвэл:

Хүснэгт №1

/ Сая төг/

Дотоодын НӨАТ	Газрын тосны НАТ	АМНАТ	АМ-ын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	ОУ-ын төсөл хөтөлбөрөөс сумдын ОНХС- д олгох урамшуулал	ОУ-ын төсөл хөтөлбөрөөс сумдын ОНХС- д олгох дэмжлэг
1,570.4	291.6	3,168.2	33.4	163.4	126.6

2021 оны төсвийн жилд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 5,353.7 сая

төгрөгөөр, Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих урсгал зарлагын хэмжээг 301.1 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Монгол улсын 2021 оны Төсвийн тухай хуульд заасан ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 5,353.7 сая төгрөгийг бүрэн олгосон байна.

1.1.3 Аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 78.7 сая төгрөгөөр дутуу хуваарилсан байна.

Төсвийн тухай хуулийн 59.5¹-т заасны дагуу Засгийн газрын 2017 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 230 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлалын 8.3.1-д “хүн амын тооноос хамаарах-40 хувь”, 8.3.2-д “алслалтаас хамаарах-30 хувь”, 8.3.3-д “нутаг дэвсгэрийн хэмжээнээс хамаарах-30 хувь” гэсэн хүчин зүйлсээр тооцож хуваарилалт хийгдэх ёстой байдаг.

Орхон аймагт орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас хуваарилагдсан 5,353.7 сая төгрөгийн орлогын шилжүүлгээс ОНХС-аас санхүүжих суурь зарлага 301.1 сая төгрөг /үүнд: *мал эмнэлгийн зардалд 26.0 сая төгрөг/, Хот тохижуулах газарт 275.1 сая төгрөг/* болон Тогтвортой амьжиргаа-3 төслийн 163.4 сая төгрөгийн дэмжлэг, 126.6 сая төгрөгийн урамшуулал, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн 100 хувь болох 33.4 сая төгрөгийн эх үүсвэрийг тус тус хасаж, үлдэх 4,729.1 сая төгрөгийг хуваарилсан байна. Төсвийн тухай хуулийн 59.2.2² дахь заалтын дагуу сумдад 4,729.1 сая төгрөгийн 30-аас доошгүй хэмжээгээр тооцож хамгийн багадаа 1,418.1 сая төгрөг хуваарилах байтал 1,340.0 сая төгрөг буюу 78.7 сая төгрөгөөр дутуу хуваарилсан байна.

Аудитаар сумдад олгох орлогын шилжүүлгийг холбогдох заавар, журмын дагуу хуваарилаагүй аймгийн Засаг даргад зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлалын 8.3.2-д “алслалтаас хамаарах-30 хувь” гэж заасны дагуу аймгийн төвөөс 33 км-ын зайтай орших 3.4 мянган хүн амтай Жаргалант суманд алслалтаас хамаарах хуваарилалт 30% болох 402.0 сая төгрөгийг олгосон байна. Орхон аймгийн хувьд Баян-Өндөр /*төвийн сум*/, Жаргалант /*хөдөөгийн сум*/ гэсэн 2 сумтай. Жаргалант сумын хувьд бусад аймгийн алслагдсан сумдтай харьцуулахад дэд бүтэц холбогдсон, цөөн хүн амтай, тээврийн хэрэгслээр 30 минут орчим яваад хүрэх газарт байрладаг.

¹ Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлгийг тооцох аргачлалыг Засгийн газар батална.

² энэ зүйлийн 59.2.1-д зааснаас бусад хэсгийн 30-аас доошгүй хувийг хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан хуваарилах;

1.1.4 Сумын ОНХС-д хуулиар олгогдох эх үүсвэрийн боломжийг судалж, орон нутгийн хөгжлийн санд нэмж төлөвлөхөөр ажиллаж байна.

Жаргалант сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 10 дугаар тогтоолоор малын тоо толгойн албан татварын хэмжээг тэмээ-500₮, адуу-1,000₮, үхэр-500₮, хонь-300 ₮, ямаа -500₮ байхаар тус тус тогтоосон байна. 2020 онд сумын жилийн эцсийн мал тооллогоор нийт 1,005 өрхийн адуу-6,137, үхэр-9,771, хонь-24,266, ямаа-29,457, тэмээ-27 нийт 69,658 толгой мал тоологдсон байна. 2021 онд малын хөлийн татварыг 50 хувь чөлөөлсөнтэй холбоотойгоор нийт 2021 оны малын хөлийн татвар 33,044.3 мянган төгрөг байхаас 50% хөнгөлөлтөөр 16,522.2 мянган төгрөгөөс 16,420.0 мянган төгрөг төвлөрч 99.4% гүйцэтгэлтэй ажилласан байна. Жаргалант сумын малын тоо толгойн албан татварын орлогоор ногоон тэжээл тарих зардлыг санхүүжүүлэхээр ажиллаж байна.

Баян-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн 02 дугаар тогтоолоор малын тоо толгойн албан татварын хэмжээг тэмээ-0 төгрөг, адуу-1000 төгрөг, Үхэр-300 төгрөг, хонь-200 төгрөг, ямаа-500 төгрөг байхаар тус тус тогтоосон. 2020 оны жилийн эцсийн мал тооллогын дүнтэй уялдуулан 2021 оны малын тоо толгойн албан татварыг 26.8 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 8.5 сая төгрөг төвлөрүүлсэн байна. Энэхүү орлогыг 2022 онд зориулалтын дагуу зарцуулахаар төлөвлөж ажиллаж байна.

1.2 Иргэдийн саналаар дэмжигдээгүй, хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдаагүй ажлыг төлөвлөж, ИТХ-аар баталсан байна.

1.2.1 Иргэдээс санал авч эрэмбэлэгдээгүй ТАХ-үүдийг аймаг, сумдын ИТХ-аар батлуулсан байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэх төсөл арга хэмжээний санал, асуулгыг 2015 онд “Эдийн засаг, санхүүгийн зөвлөгөө өгөх хөгжил төв” ТББ-тай, 2016 онд “Олон нийтийн оролцоотой хөгжлийн төв” ТББ-тай гэрээ байгуулан хийж гүйцэтгэсэн байна. Тухайн ТББ-уудын авсан санал асуулгын 1-д хот төлөвлөлт, барилгажуулалт, шинээр дэд бүтэц бий болгох ажил 16649 саналаар эрэмбэлэгдсэн байна. Санал асуулгыг үндэслэн “МОН2301 төслөөр баригдсан цэвэр бохир усны шугамын 1-р эх үүсвэр (2-р хэсэг)” ТАХ-г эхлүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 11 сарын 30-ны өдрийн 02/05 дугаар тогтоолоор аймгийн ОНХС-ын хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх 3,580.2 сая төгрөгийн 18 шинээр эхлэх хөрөнгө оруулалтын ажлыг баталсан байна. Тухайн ТАХ-үүдийг төлөвлөхдөө урьдчилсан жагсаалт боловсруулж, иргэдээр хэлэлцүүлэн эрэмбэлээгүй байна.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 02/05 дугаар тогтоолоор 2021 онд 2 суманд СОНХС-ийн хөрөнгөөр нийт 1,663.6 сая төгрөгийн ТАХ-г хэрэгжүүлэхээр баталсан байна. Эдгээр ТАХ-ыг иргэдээс санал авч хэлэлцүүлсэн эсэхийг үзэхэд сумдад иргэдээс батлагдсан маягтын дагуу саналыг

авч, багийн ИНХ-аар хэлэлцүүлэн ач холбогдол, санал авсан тоогоор эрэмбэлэн, тогтоолоор баталсан байна. Төсвийн тухай хуулийн 63.1³, 63.2⁴ дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.1.2⁵-т заасныг зөрчин иргэдийн саналаар гарч эрэмбэлэгдээгүй дараах ТАХ хэрэгжүүлсэн байна.

Баян-Өндөр сумын хувьд:

- Багийн ажлын албанд ариутгал халдваргүйжүүлэлтийн бараа материал худалдан авах,
- Говил баг, гэр хорооллын эцсээс дээш өгссөн явган хүний зам,
- Рашаант баг, Уртын голын 2,3-р гудамжийг жишиг гудамж болгон тохижуулах,
- Дэнж баг, МУИС хүртэлх явган хүний зам /3-р хэсэг/,
- Согоот баг, 6-14-р байрны ард явган хүний зам хийх,
- Рашаант баг, 30-р гудамж дахь хүүхдийн тоглоомын талбайд хаалт хийх,
- Зэст багийн иргэний танхимын тохижилт,
- Эрдэнэ багийн иргэний танхимын тохижилт,
- Баянцагаан багийн иргэний танхимын тохижилт,
- Говил багийн иргэний танхимын тохижилт,
- Антибиотикийн үлдэгдэл тодорхойлох оношлуур худалдан авах,
- Ариутгал халдваргүйжүүлэлтийн бодис худалдан авах,
- Баян-Өндөр сумын иргэний танхимын тохижилт,
- Баян-Өндөр сумын спорт зааланд тоног төхөөрөмж,
- Эко хороолол болон 7А хорооллын шаардлагатай цэгүүдэд камержуулалтын тоног төхөөрөмж худалдан авах,
- Зэрлэг ургамлын ургалт зогсоох, устгах бодис худалдан авах /Ногоон байгууламж хаших хашлага, хайс, эд материал авах/,
- Цагаанчулуут багийн гэр хорооллын гудамж дахь гэрэлтүүлгийн кабель худалдан авах,
- Багуудын ажлын албанд халдвар хамгааллын хэрэгсэл авах,
- Баян-Өндөр сумын гамшгаас хамгаалах бэлэн байдлын үеийн материаллаг баазыг нэмэгдүүлэх зардал.

Жаргалант сумын хувьд:

- ЕБС-ийн эмэгтэй кабинетын засвар үйлчилгээ, тоног төхөөрөмж,
- Эмнэлгийн өргөтгөлийн хашаа барих,
- ЕБС-ийн интернэт шинэчлэх,
- Соёл мэдээллийн төвд тоног төхөөрөмж худалдан авах,
- Усалгааны бага оврын иж бүрдэл худалдан авах,
- Саран тармуур худалдан авах,
- Өвлийн хүлэмж төслийн хүрээнд блок худалдан авах,
- Өвлийн хүлэмж төслийн хүрээнд элс, хайрга, дайрга татан авах,
- Ногоочдыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд тракторын анжис худалдан авах,
- Дулаан-Уул багийн зарим худагт мотор, насос суурилуулах,
- Зураг төсвийн 16 ажил.

³ Баг хорооны Засаг дарга ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулах

⁴ Энэ хуулийн 63.1-д заасан санал болон баг, хорооны ИНХ-д гарсан саналыг ИНХ хэлэлцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгоно.

⁵ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх;

Аудитаар Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.1.2⁶ дахь заалтыг мөрдөж ажиллаагүй аймаг, сумдын Засаг дарга нарт зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

1.2.2 ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн зарим ТАХ-г төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулаагүй байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2021 онд нийт 4,068.0 сая төгрөгийн 28 ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. */2018 оноос хойш шилжсэн 1 ажил, 2020 оноос шилжсэн 8 ажил/*

Дээрх ажлуудын 25 нь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр /2021-2024/, аймгийн эдийн засаг нийгмийг 2021 онд хөгжүүлэх үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичгүүдтэй уялдсан хэдий ч 3 ТАХ уялдаагүй байна. Үүнд:

- Орон сууцны 4-р хорооллын 20-р байрны 1-р блокийн дээврийн засвар,
- Орон сууцны 1-р хорооллын 15-р байрны 2-р блокийн дээврийн засвар,
- Орон сууцны 3-р хорооллын 19-р байрны 2-р блокийн дээврийн засвар.

Баян-Өндөр сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим ТАХ нь сумын Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдаагүй байна. Үүнд:

- Багийн ажлын албанд ариутгал халдваргүйжүүлэлтийн бараа материал худалдан авах,
- Зэст багийн иргэний танхимын тохижилт,
- Эрдэнэ багийн иргэний танхимын тохижилт,
- Баянцагаан багийн иргэний танхимын тохижилт,
- Говил багийн иргэний танхимын тохижилт,
- Ариутгал халдваргүйжүүлэлтийн бодис худалдан авах,
- Баян-Өндөр сумын иргэний танхимын тохижилт.

Жаргалант сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим ТАХ нь сумын Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдаагүй байна. Үүнд:

- ЕБС-ийн эмэгтэй кабинетын засвар үйлчилгээ, тоног төхөөрөмж,
- ЕБС-ийн интернэт шинэчлэх,
- Цөм сүргийн өвөлжилт хаваржилтын бэлтгэл ханган өвс тэжээл худалдан авах.

Аудитаар Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.1.1⁷ дахь заалтыг мөрдөж ажиллаагүй аймаг, сумдын Засаг дарга нарт зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

⁶ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх;

⁷ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх;

1.2.3 Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр чиг үүрэгт нийцээгүй болон сумын хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр баталсан байна.

Баян-Өндөр сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой 145.3 сая төгрөгийн 3 ТАХ-г аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Орон сууцны 4-р хорооллын 20-р байрны 1-р блокийн дээврийн засвар,
- Орон сууцны 1-р хорооллын 15-р байрны 2-р блокийн дээврийн засвар,
- Орон сууцны 3-р хорооллын 19-р байрны 2-р блокийн дээврийн засвар.

ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх ТАХ-ны нэгдсэн жагсаалтыг 8 дугаар сарын 10-ны өдрийн дотор ЗД-ын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлээгүй, ТАХ-г аймгийн ИТХ батлагдсан маягтын дагуу батлаагүй байна.

Дээрх үйл ажиллагаа нь Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 7.2⁸, 7.5⁹, 7.6¹⁰, 7.7¹¹, 7.7¹² дахь заалтуудтай нийцээгүй тул зөвлөмж хүргүүлэв.

⁸ Ажлын хэсэг аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урьдчилсан жагсаалтыг дараах үзүүлэлтүүдийг харгалзан үзэж боловсруулна.

⁹ Урьдчилсан жагсаалтыг аймаг, нийслэлийн Иргэний танхимаар дамжуулан нийтэд зар мэдээ хүргэсний үндсэн дээр нээлттэй хэлэлцүүлгийг 7 дугаар сард багтаан 2-оос доошгүй удаа зохион байгуулна.

¹⁰ Аймаг, нийслэлийн Засаг дарга иргэд, иргэний нийгмийн байгууллагаас хамгийн олон санал авсан, ажлын хэсгийн санал, дүгнэлтээр баталгаажсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан танилцуулна.

¹¹ Ажлын хэсэг хэлэлцүүлгийн үр дүнг нэгтгэн аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэгдсэн жагсаалтыг 8 дугаар сарын 10-ны өдрийн дотор Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

¹² Аймаг, нийслэлийн ИТХ нь аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэгдсэн саналыг хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ тус бүрээр хэлэлцэн энэхүү журмын 8 дугаар хавсралтад заасан маягтын дагуу батална.

Орхон аймаг дахь
Төрийн аудитын
газар

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх:

Бүлэг 2

ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад зарим холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүйгээс үр дүн муутай ажлууд хийгдсэн байна.

2.1 ОНХС-ийн хөрөнгөөр ТАХ хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийн зарим заалтыг зөрчсөн байна.

2.1.1 Сангийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг хуулийн зарим заалтуудыг зөрчин зохион байгуулсан байна.

2021 онд аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр Баян-Өндөр суманд 730.5 сая төгрөгийн төсөвт өртгөөр 40 ТАХ-г төлөвлөн, хэрэгжүүлсэн байна.

Аудитаар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний сонгон шалгаруулалтын журмын хэрэгжилтийг үзэхэд нийт ХАА-ны 24 ТАХ буюу 60.0 хувийг ХА, 13 ТАХ буюу 32.5 хувийг ШГ, 1 ТАХ буюу 2.5 хувийг НТШ, 2 ТАХ буюу 5 хувийг олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журмаар байгуулсан байна.

Баян-Өндөр сумын 2021 оны ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн ТАХ-ний гүйцэтгэгч сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааны явцад дараах нийтлэг зөрчлүүд гарсан байна. Үүнд:

- 13 ТАХ-д шууд гэрээ байгуулахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийн 14-16-р зүйлийн шаардлагыг хангасан эсэх талаар баримтуудыг бүрэн бүрдүүлж аваагүй, шаардлагыг хангаагүй компаниудтай гэрээ байгуулсан нь тус хуулийн 34.2¹³ дахь заалттай нийцэхгүй байна.
- Сангийн сайдын 2012 оны 212 дугаар тушаалаар батлагдсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, урамшууллыг зохицуулах журам”-д заасны дагуу тендерийн үнэлгээний хороог 3-5 хүний бүрэлдэхүүнтэйгээр сумын Засаг даргын захирамжаар томилсон байна. 11 ТАХ-ний үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд Баян-Өндөр сумын ИТХ-ын төлөөлөгч орж ажилласан байна.
- Нээлттэй тендер шалгаруулалтаар зохион байгуулсан Баян-Өндөр сумын иргэний танхимын тохижилт ажлын тендерийн урилгыг үндэсний өдөр тутмын сонинд нийтлээгүй нь хуулийн 21.1¹⁴ дэх заалттай нийцэхгүй байна.
- Баян-Өндөр сумын иргэний танхимын тохижилтын ажлын гүйцэтгэгч нь гүйцэтгэлийн баталгаагаа ирүүлээгүй байхад нь гэрээ байгуулсан. /Тендерийн баримт бичигт гүйцэтгэлийн баталгаа шаардсан./

¹³ Энэ хуулийн 34.1-д заасан нөхцөлийн дагуу шууд гэрээ байгуулахад захиалагч энэ хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлагыг хангасан, тухайн бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэх чадавхтай нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдтэй хэлэлцээ хийж, техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хамгийн сайн хангасан этгээдтэй энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах бөгөөд хэлэлцээний үед хүрсэн аливаа тохиролцоог гэрээнд тусгана.

¹⁴ Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, худалдан авах ажиллагааны цахим систем болон хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ.

Жаргалант сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2021 онд 827.6 сая төгрөгийн гэрээний дүнтэй 40 ТАХ-ний сонгон шалгаруулалтын журмын хэрэгжилтийг үзэхэд 6 ТАХ буюу 15 хувь нь харьцуулалтын аргаар, 33 ТАХ буюу 82.5 хувь нь ШХА-аар, 1 ТАХ буюу 2.5 хувь нь НТШ-аар тус тус зохион байгуулагдахаар төлөвлөгөөнд тусгагдсан байна.

Жаргалант сумын 2019 оны ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн ТАХ-ний гүйцэтгэгч сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааны явцад дараах зөрчлүүд гарсан байна. Үүнд:

- 33 ТАХ-д шууд гэрээ байгуулахдаа хуулийн 14-16-р зүйлийн шаардлагыг хангасан эсэх талаар баримтуудыг бүрэн бүрдүүлж аваагүй байна. Мөн 14-16-р зүйлийн шаардлагыг хангаагүй компаниудтай гэрээ байгуулсан нь хуулийн 34.2¹⁵ дахь заалттай нийцэхгүй байна.
- ХА-аар зохион байгуулсан тендерүүдийн үнэлгээний хороог сумын ЗДТГ-н төлөөлөл 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан нь 47.4¹⁶ заалттай нийцэхгүй байна.
- НТШ болон ХА-аар зохион байгуулсан тендерүүдийн үнэлгээний хороодын нээлтийн болон шалгаруулсан хурлын тэмдэглэлүүд байхгүй байгаа нь хуулийн 47.7¹⁷ дахь заалттай нийцэхгүй байна.
- Тендерт шалгарсан компанид хүргүүлсэн гэрээ байгуулах эрх олгосон албан бичигт ажлын 5 хоногийн дараа гэрээ байгуулах талаар зааж өгсөн нь хуулийн 29.2¹⁸ дахь заалттай нийцэхгүй байна.

Дээрх зөрчлийг гаргасан сумдын Засаг дарга нарт хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.1.2 Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

Төсвийн тухай хууль болон ОНХС-ын журмаар аймаг, сумд ОНХС-ын хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ний чиг үүргийг тодорхойлсон байна. Төсвийн тухай хууль, ОНХС-ын журамд заасан чиг үүрэгт хамаарахгүй урсгал зардлын шинжтэй ТАХ-г хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Баян-Өндөр сумын багуудын ажлын албанд ариутгал халдваргүйжүүлэлтийн бараа материал худалдан авахад 25.0 сая төгрөг,
- Баян-Өндөр сум ариутгал халдваргүйжүүлэлтийн бодис худалдан авах
- Баян-Өндөр сумын багуудын ажлын албанд халдвар хамгааллын хэрэгсэл авах

¹⁵ Энэ хуулийн 34.1-д заасан нөхцөлийн дагуу шууд гэрээ байгуулахад захиалагч энэ хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлагыг хангасан, тухайн бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэх чадавхтай нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдтэй хэлэлцээ хийж, техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хамгийн сайн хангасан этгээдтэй энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах бөгөөд хэлэлцээний үед хүрсэн аливаа тохиролцоог гэрээнд тусгана.

¹⁶ Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна.

¹⁷ Үнэлгээний хорооноос гаргасан шийдвэр /цаашид “үнэлгээний дүгнэлт” гэх/ нь хурлын тэмдэглэл хэлбэртэй байх бөгөөд хорооны гишүүдийн олонх дэмжиж гаргасан шийдвэр, түүний үндэслэл, холбогдох бүх мэдээллийг агуулсан байна.

¹⁸ Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын 6-аас доошгүй хоногийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулна.

- Баян-Өндөр сумын гамшгаас хамгаалах бэлэн байдлын үеийн материаллаг баазыг нэмэгдүүлэх зардалд
- Жаргалант сумын өвлийн хүлэмж төслийн блок худалдан авахад 17.1 сая төгрөг,
- Жаргалант сумын өвлийн хүлэмж төслийн хүрээнд элс, хайрга, дайрга татан авахад 7.8 сая төгрөг.

ОНХС-ын хөрөнгөөр бараа материал худалдан авсан нь Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.1-д “Аймаг, нийслэл, сум, дүүрэг нь ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлд заасан чиг үүрэгт хамаарах энэ журмын 4.2-т зааснаас бусад хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх ажлыг санхүүжүүлнэ.” гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2.1 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-г үндэслэлтэй төлөвлөж, үр дүнг бодитой тодорхойлоогүйгээс хүндрэл бэрхшээл тулгарч байна.

ОНХС-ын хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлтийг үндэслэлтэй хийгээгүйгээс хүндрэлтэй асуудлууд гарч байгаа нь ОНХС-ийн хөрөнгийн үр нөлөөг бууруулахад хүргэж байна. Тухайлбал:



Аймгийн ОНХС-ын хөрөнгөөр 2021 онд хийгдсэн Баян-булаг багт халуун, хүйтэн, цэвэр усны төв шугамаас салбар шугам татах ажил, ус дамжуулах төв баригдсан боловч, усны төв шугамаас 1-р конторыг холбоогүй, хэзээ холбогдох нь тодорхойгүй байна. Мөн авто зам хөндлөн эвдэж холбохоор ажлын зураг хийгдсэн, Баян-Өндөр сумын Баянцагаан, Рашаант багуудын цэвэр, бохир усны шугамын ажлын зураг нь айлын хашаан дундуур гарч, хувийн орон сууцыг нураагдахаар ажлын зураг хийгдсэн байна.



ОНХС-ын хөрөнгө оруулалтаар 2013 онд хийгдсэн 640.5 сая төгрөгийн өртөгтэй “Жаргалант сумын хойд хороололд цэвэр усны шугам тавих, нөөцийн усан сан байгуулах” одоог хүртэл ашиглалтгүй байна.



ОНХС-ын хөрөнгө оруулалтаар 2015 онд хийгдсэн Байцааны 505 тонны зоорийг машин, тоног төхөөрөмжийн агуулах хэлбэрээр ашиглаж байна.

Өмнөх онуудад Жаргалант суманд хийгдсэн хойд хороололд цэвэр усны шугам тавих, нөөцийн сан байгуулах, байцааны зоорь барих зэрэг ажлуудын урсгал зардал, ажиллах хүчний асуудлыг шийдээгүйгээс бүрэн ашигладаггүй, тухайн хөрөнгүүдийн эвдрэл гэмтэлд засвар үйлчилгээ хийдэггүй, хадгалалт хамгаалалт хангалтгүй байна.

2.2.2 Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээ нь ирээдүйд орон нутгийн хөгжилд хувь нэмрээ оруулахаар байна.

Аймгийн ОНХС-ын хөрөнгөөр 2021 онд “МОН2301 төслөөр баригдсан цэвэр бохир усны шугамын 1-р эх үүсвэр (2-р хэсэг)”, миний гудамж-бидний гэр” төслийн хүрээнд гэр хороололд баригдсан цэвэр, бохир усны төв шугамаас салбар шугам, сүлжээ татах ажил, гэр хороолол дундуур сайжруулсан шороон замын ажил, орон сууцны дээврийн засварын ажлууд хийгдсэн байна.

Баян-Өндөр сумын ОНХС-ын хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлсэн ТАХ-үүд нь сумын хөгжилд өнгө үзэмж нэмсэн тохижилтын ажлууд голлон хийгдсэн байна.

Жаргалант сумын ОНХС-ын хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлсэн ТАХ-үүд нь тусгай шилжүүлгийн байгууллагуудын байрны засвар үйлчилгээ, тоног төхөөрөмж худалдан авахад болон хөдөө аж ахуйн салбарт чиглэсэн ажлууд голлон хийгдсэн байна.

2.2.3 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон зарим хөрөнгө ашиглалтын шаардлага хангахгүй байна.

2021 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний ашиглалтын байдалтай танилцахад дараах зөрчил дутагдал илэрсэн. Үүнд:



Аймгийн ОНХС-ын хөрөнгөөр 2021 онд хийгдсэн орон сууцны 3-р хорооллын 19-р байрны 2-р блокийн дээврийн засварын ажил чанаргүй хийгдэж дээврээс борооны ус орсон байдалтай байна.



Жаргалант сумын ОНХС-ын хөрөнгө оруулалтаар 2021 онд 30.0 сая төгрөгийн санхүүжилтээр өвс тэжээл худалдан авсан. Тухайн өвс нь бороо болон хайлсан цасанд норсон нь цас, борооноос хамгаалах саравч байхгүйгээс өвсний чанар муудсан. 2021 онд тухайн бэлтгэсэн өвсийг зарцуулж дуусаагүй байна.



Баян-Өндөр сумын ОНХС-ын хөрөнгө оруулалтаар 2021 онд хийгдсэн 15.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Баянбулаг багийн төв зам дагуух явган хүний замын шинэчлэлтийн ажил эвдэрч хэмхэрсэн байна.

Дээрх зөрчлүүд нь Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 9.12¹⁹ дахь заалттай нийцэхгүй байна.

¹⁹ ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон барилга байгууламж, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг хуульд заасны дагуу өмчлөлд бүртгэж авсан байгууллага нь ашиглалт, хадгалалт, хамгаалалтын зардлыг хариуцна.”

Орхон аймаг дахь
Төрийн аудитын
газар

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх:

Бүлэг 3

ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах тодорхой арга хэмжээ авч, удирдлагын мэдээллийн системд мэдээллээ бүрэн оруулах шаардлагатай байна.

3.1 Аймгийн Засаг даргын дэргэдэх СХАА-аас ОНХС-ийн 2020 оны үйл ажиллагаанд, 2021 оны хэрэгжүүлсэн ажлуудын захиалагчийн хяналтыг “Хот байгуулалт, барилга захиалагчийн алба” ОНӨААТҮГ-аас хэрэгжүүлсэн бол аймаг, сумдын ИТХ-аас ямар нэгэн хяналт хэрэгжүүлээгүй байна.

3.1.1 Аймаг, сумдын ИТХ-аас ОНХС-ийн зарцуулалт, ТАХ-ны үр дүнд хяналт хэрэгжүүлээгүй байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 9.4-т “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд төв, орон нутгийн хууль, хяналт, дотоод ба хөндлөнгийн аудитын байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дэргэдэх хороо болон иргэд, иргэний нийгмийн байгууллагууд Монгол Улсын Төрийн аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны “Дүрэм батлах тухай” 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм” болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавина” гэж заасан байна.

Аймаг, сумдын ОНХС-аар хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилтэд ИТХ-н дэргэдэх Хяналтын хороо болон иргэд иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавьж ажиллаагүй байна.

3.1.2 ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Аймаг, сумдын ОНХС-аар хэрэгжүүлсэн ажлуудын гүйцэтгэлийг “Хот байгуулалт, барилга захиалагчийн алба” ОНӨААТҮГ тухай бүрд нь ил далд ажлын актаар баталгаажуулж, санхүүжилтийг гүйцэтгэл гарсан тухай бүрд нь олгосон байна.

“Хот байгуулалт, барилга захиалагчийн алба” ОНӨААТҮГ нь 2021 онд аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 27 ажил, Баян-Өндөр сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 26 ажил, Жаргалант сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 5 ажилд тус тус захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.

3.1.3 СХАА-аас 2 суманд хийсэн хяналт шалгалтын зөвлөмжийн хэрэгжилт тайлант онд бүрэн хангагдсан байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-д гүйцэтгэлийн, санхүүгийн хяналт шалгалтыг Төсвийн тухай хуулийн 69.1²⁰-д заасан байгууллага хэрэгжүүлнэ гэж заасан байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2021 оны хяналт, шалгалтын төлөвлөгөө, аймгийн Засаг даргын баталсан удирдамжуудын дагуу Баян-Өндөр, Жаргалант сумдын 2020 оны ОНХС-ийн үйл ажиллагаанд аудит хийсэн байна.

ТАГ-аас 2021 онд хийсэн аймаг, сумдын ОНХС-ийн 2020 оны СТА-аар өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийг үзэхэд дараах байдалтай байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн байдал

/сая төгрөг/

Үзүүлэлт	Зөвлөмж		Хугацаандаа хэрэгжсэн		Хугацаандаа хэрэгжээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Орхон аймаг	1	0	1	0	0	0	100%
Баян-Өндөр сум	1	62.9	1	62.9	0	0	100%
Жаргалант сум	1	9.5	1	9.5	0	0	100%

2021 онд хийгдсэн 2020 оны СТА-аар өгсөн зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

3.2 ОНХС-ийн үйл ажиллагааны явцын мэдээг холбогдох байгууллагад хүргүүлсэн хэдий ч сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнг удирдлагын мэдээллийн системд хангалтгүй мэдээлсэн байна.

3.2.1 ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээний тайлан мэдээг дээд шатны байгууллагад хүргүүлэхдээ хууль, журамд заасан хугацааг баримталж ажилласан хэдий ч ХБТХОХ нь цаашид даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулаагүй байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 9.3-т “Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг сум, дүүрэг тус бүрээр хагас жил тутамд гарган, дүгнэлт өгч, цаашид даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг

²⁰ Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна.

боловсруулан аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулж, холбогдох асуудлаар тодорхой шийдвэрийг гаргуулна” гэж заасан байна.

2021 онд ОНХС-ийн хэрэгжилтэд дүгнэлт өгөх, дүн шинжилгээ хийх, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал зөвлөмжийг боловсруулж шийдвэрлүүлэх ажил хийгдээгүй байна.

Дээрх зөрчилд холбогдох албан тушаалтанд зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 9.2²¹-т заасан тайлан мэдээг хүргүүлсэн эсэхийг үзэхэд сумдын ЗДТГ-ын дарга нь ХБТХОХ-т хэрэгжилтийн жилийн тайланг хүргүүлсэн байна.

Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.1-д “... сумын санхүүгийн алба нь ОНХС-ийн төсвийн гүйцэтгэлийн тайланг энэ журмын 10 дугаар хавсралтад заасны дагуу аймгийн СТСХ-т Төсвийн тухай хуульд заасан санхүү, төсвийн гүйцэтгэлийг тайлагнах хугацаанд тайлагнана” гэж заасан байна.

Дээрх журам заасны дагуу 2 сум 2021 оны ОНХС-ийн жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайланг холбогдох хавсралт маягтаар аймгийн СТСХ-д ирүүлж, мэдээллийн санд мэдээлсэн байна.

3.2.2 Жаргалант сумын ОНХС-ийн хөрөнгөөр 69.3 сая төгрөгийн өртгөөр хийгдсэн зураг, төсвүүдийг нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнаагүй байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2021 онд хийгдсэн 28 ТАХ-г бүртгэл тайланд тусгасан байдлыг шалгахад “Миний гудамж, бидний гэр” төслийн хүрээнд хийгдсэн цэвэр, бохир усны төв шугамаас салбар шугам сүлжээ татах ажлуудыг Орон нутгийн өмчийн газар, сайжруулсан шороон замын ажлуудыг Хот тохижуулах газар, МОН-2301 төслөөр баригдсан цэвэр усны шугамын 1-р эх үүсвэр (2-р хэсэг) болон дээвэр засварын ажлуудыг “Эрдэнэт-Ус ДТС” ОНӨХК данс бүртгэлдээ тус тус тусгаж, тайлагнасан байна.

Баян-Өндөр сумын ОНХС-ын хөрөнгөөр 2021 онд хийгдсэн 40 ТАХ-г бүртгэл тайланд тусгасан байдлыг шалгахад гэрэлтүүлгийн ажлуудыг “Эрдэнэт-Ус ДТС” ОНӨХК, явган хүний замын ажлууд болон тоглоомын талбайн ажлуудыг Хот тохижуулах газар, Антибиотекийн үлдэгдэл тодорхойлох оношлуурыг Мал эмнэлгийн газар, бусад ТАХ-г Баян-Өндөр сумын ЗДТГ данс бүртгэлдээ бүрэн тусгасан байна.

Жаргалант сумын ОНХС-ын хөрөнгөөр 2021 онд хийгдсэн 24 ТАХ-г бүртгэл тайланд тусгасан байдлыг шалгахад цамхагт гэрэл суурилуулах ажлуудыг “Эрдэнэт-Ус ДТС” ОНӨХК, тусгай шилжүүлгийн байгууллагуудын засвар, тоног төхөөрөмжүүдийг тухайн байгууллагуудад, бусад ТАХ-г Жаргалант сумын ЗДТГ данс бүртгэлдээ тусгасан байна. Харин 69.3 сая төгрөгийн өртгөөр хийгдсэн зураг төсвийн 16 ажлуудыг бүртгэл тайланд тусгаагүй байна.

²¹ Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж дараа оны 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэх ба энэ журмын 9.9- д заасан мэдээллийг багтаана.

3.2.3 Сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнг удирдлагын мэдээллийн системд хангалтгүй мэдээлсэн байна.

Сангийн яамны удирдлагын системд ОНХС-аар Орхон аймагт хэрэгжүүлсэн ТАХ-ний мэдээллүүдийг оруулаагүй байна.

Жаргалант сумын хувьд төлөвлөлт хэсгийн мэдээллүүдийг оруулсан боловч хэрэгжилт, тайлан, хяналтын хэсгийн мэдээллийг оруулаагүй байна.

Харин Баян-Өндөр сумын хувьд хяналтын хэсгээс бусад хэсгийн мэдээллүүдийг бүрэн оруулсан байна.

3.2.4 ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалтын талаар Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цаг тухай бүрд нь мэдээлсэн байна.

Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3.1.15-д “орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөөг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор, гүйцэтгэлийн сар, улирал, хагас болон бүтэн жилийн мэдээг дараа сарын 8-ны дотор энэ журмын 11 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу тус тус цахимаар;” шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэхээр заажээ. ШДНЦХ-д мэдээлээ хэрхэн байршуулсныг шалгахад Жаргалант сумын хувьд ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэл (Бүтэн жилээр, Сар бүр) 7 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, Баян-Өндөр сумын хувьд ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэл (Бүтэн жилээр, Сар бүр) 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Дээрх мэдээлэл хугацаа хоцроож мэдээлснийг эс тооцвол бусад мэдээллийг бүрэн оруулсан байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг батлагдсан аргачлалын дагуу тооцон төлөвлөж, санд олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу олгосон байна.
- Аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 78.7 сая төгрөгөөр дутуу хуваарилсан байна.
- Сумын ОНХС-д хуулиар олгогдох эх үүсвэрийн боломжийг судалж, орон нутгийн хөгжлийн санд нэмж төлөвлөхөөр ажиллаж байна.
- Иргэдээс санал авч эрэмбэлэгдээгүй ТАХ-үүдийг аймаг, сумдын ИТХ-аар батлуулсан байна.
- ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн зарим ТАХ-г төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулаагүй байна.
- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр чиг үүрэгт нийцээгүй болон сумын хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр баталсан байна.
- Сангийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг хуулийн зарим заалтуудыг зөрчин зохион байгуулсан байна.
- Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.
- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-г үндэслэлтэй төлөвлөж, үр дүнг бодитой тодорхойлоогүйгээс хүндрэл бэрхшээл тулгарч байна.
- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээ нь ирээдүйд орон нутгийн хөгжилд хувь нэмрээ оруулахаар байна.
- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон зарим хөрөнгө ашиглалтын шаардлага хангахгүй байна.
- Аймаг, сумдын ИТХ-аас ОНХС-ийн зарцуулалт, ТАХ-ны үр дүнд хяналт хэрэгжүүлээгүй байна.
- ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.
- СХАА-аас 2 суманд хийсэн хяналт шалгалтын зөвлөмжийн хэрэгжилт тайлант онд бүрэн хангагдсан байна.
- ОНХСангийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээний тайлан мэдээг дээд шатны байгууллагад хүргүүлэхдээ хууль, журамд заасан хугацааг баримталж ажилласан хэдий ч ХБТХОХ нь цаашид даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулаагүй байна.
- Жаргалант сумын ОНХС-ийн хөрөнгөөр 69.3 сая төгрөгийн өртгөөр хийгдсэн зураг, төсвүүдийг нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнаагүй байна.
- Сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнг удирдлагын мэдээллийн системд хангалтгүй мэдээлсэн байна.
- ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалтын талаар Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цаг тухай бүрд нь мэдээлсэн байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Үүнд:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА С.БАТЖАРГАЛ ТАНАА

1. Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7.3²², 7.5²³, 7.6²⁴, 7.7²⁵, 7.8²⁶ дахь заалтуудыг мөрдөж ажиллах.
2. Төсвийн тухай хуулийн 59.2.2²⁷ дахь заалтын дагуу аймгийн ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг хуваарилж байх.
3. Сангийн яамны удирдлагын системд ОНХС-аар Орхон аймагт хэрэгжүүлсэн ТАХ-ний мэдээллүүдийг цаг тухайд нь, үнэн зөв, иж бүрэн оруулах.

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТЭСТ

1. ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг сум тус бүрээр гарган, дүгнэлт өгч, цаашид даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймгийн Засаг даргад танилцуулж, холбогдох асуудлаар тодорхой шийдвэрийг гаргуулж байх.

БАЯН-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГА Б.БААСАНСҮРЭН ТАНАА

1. Иргэдийн саналаар дэмжигдээгүй, хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдаагүй ажлыг төлөвлөж, ИТХ-аар батлуулахгүй байх.
2. Шууд гэрээ байгуулахдаа ТБОНӨХБАҮХАТ хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлагыг хангасан компанитай гэрээ байгуулж байх.
3. НТШ-аар зохион байгуулсан тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонинд нийтлэх.
4. Сангийн яамны удирдлагын системд ОНХС-аар хэрэгжүүлсэн ТАХ-ний мэдээллүүдийг цаг тухайд нь, үнэн зөв, иж бүрэн оруулах.

²² Ажлын хэсэг аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урьдчилсан жагсаалтыг сум, дүүргээс ирүүлсэн сум, дүүргийн төсвөөр бие даан хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтад үндэслэн дараах үзүүлэлтүүдийг харгалзан үзэж боловсруулна. Үүнд:

²³ Урьдчилсан жагсаалтыг аймаг, нийслэлийн Иргэний танхимаар дамжуулан, нийтэд зар мэдээ хүргэсний үндсэн дээр нээлттэй хэлэлцүүлгийг жил бүрийн 7 дугаар сард багтаан зохион байгуулна.

²⁴ Ажлын хэсэг хэлэлцүүлгийн үр дүнг нэгтгэн аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэгдсэн жагсаалтыг ОНХС-ийн УМС-ийн маягтын дагуу хэвлэж жил бүрийн 8 дугаар сарын 10-ны өдрийн дотор Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

²⁵ Аймаг, нийслэлийн Засаг дарга нь Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн нэгдсэн жагсаалтыг хурлын тэмдэглэл болон орон нутгийн төсвийн төсөлд тусган аймаг, нийслэлийн ИТХ-аар хэлэлцүүлэхээр хүргүүлнэ.

²⁶ Аймаг, нийслэлийн ИТХ нь аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэгдсэн саналыг хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ тус бүрээр хэлэлцэн энэ журмын 8 дугаар хавсралтад заасан маягтын дагуу батална.

²⁷ энэ зүйлийн 59.2.1-д зааснаас бусад хэсгийн 50-аас доошгүй хувийг хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан хуваарилах;

ЖАРГАЛАНТ СУМДЫН ЗАСАГ ДАРГА Б.ЗОРИГТБАЯР ТАНАА

1. Иргэдийн саналаар дэмжигдээгүй, хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдаагүй ажлыг төлөвлөж, ИТХ-аар батлуулахгүй байх.
2. Шууд гэрээ байгуулахдаа ТБОНӨХБАҮХАТ хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлагыг хангасан компанитай гэрээ байгуулж байх.
3. Тендерүүдийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл Төрийн бус байгууллагын 2-оос доошгүй төлөөлөгч, сумын ИТХ-аас томилсон иргэдийг оролцуулах.
4. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын 6-аас доошгүй хоногийн дараа, тендерийн хүчинтэй байх хугацаанд гэрээ байгуулж байх.
5. Сангийн яамны удирдлагын системд ОНХС-аар хэрэгжүүлсэн ТАХ-ний мэдээллүүдийг цаг тухайд нь, үнэн зөв, иж бүрэн оруулах.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

Тайланд тусгах саналгүй тул албан бичгүүдийг хавсаргав.